

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
3.1. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал	10
3.2 Цалин хөлстэй холбоотой асуудал	11
3.3 Дүрмийн сантай холбоотой асуудал	12
3.4 Татварын тайлангийн талаар:	12
3.5 Бараа материалын бүртгэлийн талаар:	13
3.6 Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар:	13
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15
4.1. Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	15
4.2. Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан	17
4.3. Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	19
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан	22
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	23
4.6. Аудит хийсэн Нэмэлт санхүүжилтийн тайлан.....	25
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	26

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.04 № 06/561
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Геронтологийн үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд тусгагдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Геронтологийн үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Геронтологийн үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудлууд


Геронтологийн үндэсний төв нь 1,914.8 мянган төгрөгийн үндсэн цалин, 2,330.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин, 4,685.4 мянган төгрөгийн ээлжийн амралтын олговор нийт 8,930.2 мянган төгрөгийн цалин хөлсийг илүү тооцож олгосон, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлын ангиллыг 49,700.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, 18,390.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан боловч зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн зарчим” 5.1.4-т “үнэн зөв байх”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Геронтологийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Ерөнхий захирал Р.Хишигжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн цалин хөлс дансны нягтлан бодох бүртгэл, тайлагналыг холбогдох стандарт дүрэм, журмын дагуу бүртгэхтэй холбоотой зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Геронтологийн үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Геронтологийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 30-аас 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал Т.Одончимэг хоёр дахь шатны, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг анхан шатны хяналт хэрэгжүүлэхээр, ахлах аудитор О.Цэндхүү, аудиторын туслах Т.Алтанчимэг, М.Батмагнай, Х.Гэрэлбаяр нар хариуцаж хэрэгжүүлэв.

Геронтологийн үндэсний төв нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/26 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Геронтологийн үндэсний төвийн эрхэм зорилгыг монгол хүний насжилтын байдал түүнд нөлөөлөх хүчин зүйлийг судалж, ахмад настанд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн арга зүйгээр хангах сургалт, сурталчилгаа явуулахад оршино гэж тодорхойлсон байна.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 226 дугаар тушаалаар тус төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол хүний насжилтын байдал түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, хянах үйл ажиллагаа явуулах;
- Нотолгоонд суурилсан геронтологи болон гериатрийн тусламжийг настан буурлуудад үзүүлж, настанд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх;
- Эрүүл насжилтыг дэмжих олон талт үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах, удирдан чиглүүлэх, олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтрах ажиллагааг өргөжүүлэн чиглүүлэх;
- Геронтологийн болон гериатрийн чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн болон бусад байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хяналт үнэлгээ, лавлагаа тусламж үзүүлэх;
- Насжилт, настны эмгэг судлалын чиглэлээр эрүүл мэндийн мэргэжилтэн, бусад мэргэжилтэнд төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт, хүн амын зорилтот бүлэг, настанд зориулсан сургалтыг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 382 тоот тогтоолоор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”, “Төрийн албан хаагчид докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл олгох журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”;
- Засгийн газрын 2019 оны 5 тоот тогтоолоор “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”, “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан, хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт”, “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”;
- Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолоор баталсан “Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”, “Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”, “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл”;
- “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол”;
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;
- Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг Сангийн сайдын 2019 оны 74 дугаар тушаалаар баталсан.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус төвийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2011 онд боловсруулагдсан Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй, шинэчлэн боловсруулах шаардлагатай гэж үзсэн тул түүнийг сайжруулах зөвлөмж өгсөн.

Геронтологийн үндэсний төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “ACOLOUS 3.0” програм хангамж ашигладаг байна.

Геронтологийн үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Геронтологийн үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 7 чиглэлд 18 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшин дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 909,695.9 мянган төгрөгөөс тооцон 18,193.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож 18,193.9 мянган төгрөгөөр тооцсон нь Геронтологийн үндэсний төвийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, үйл ажиллагааны орлого, зардалд эрсдэл дунд байгаатай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Геронтологийн үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 56,712.8 мянган төгрөгөөр буюу 10.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, биет хөрөнгө, хуримтлагдсан үр дүн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	500.0	1.8	-498.2
Авлага	22,392.6		-22,392.6
Бараа материал	100,257.7	105,478.1	5,220.4
Биет хөрөнгө	342,912.2	304,196.5	-38,715.7
Биет бус хөрөнгө	58,802.1	58,475.4	-326.7
Нийт хөрөнгө	524,864.6	468,151.8	-56,712.8

Засгийн газрын оруулсан капитал /засгийн газрын сан/	478,903.3	478,903.3	
Хуримтлагдсан үр дүн	-83,537.0	-140,249.8	56,712.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	129,498.3	129,498.3	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	524,864.6	468,151.8	-56,712.8

Авлагын дансны үлдэгдэл 22,392.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны эхний үлдэгдэлд тусгагдсан авлагыг бүрэн барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5,220.4 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материалын өсөлттэй холбоотой байна.

Биет болон биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 39,042.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 6,143.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар, 26,250.3 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 71,435.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 56,712.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн 56,712.8 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Геронтологийн үндэсний төв тайлант онд 797,645.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 797,404.4 мянган төгрөгийг зарцуулж 99.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлангийн хугацаанд нийт 23615 хүн үзлэг, эмчилгээ, оношилгоо, шинжилгээнд хамрагдаж, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой улсын төсвөөс 540,729.5 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 243,912.4 мянган төгрөг, үндсэн ба туслах үйл ажиллагаанаас 13,489.7 мянган төгрөг нийт 798,313.6 мянган төгрөгийн төсөв төвлөрснөөс урсгалд зардалд 797,404.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Геронтологийн үндэсний төв нь тайлант онд 70,898.5 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар авч 70,514.5 мянган төгрөгийг зарцуулж 384.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Эрүүл мэндийг дэмжих сангаас “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр” хэрэгжүүлэх ажлын хүрээнд 22,392.6 мянган төгрөг;
- Эрүүл мэндийн даатгалын газраас урьдчилан сэргийлэх багцын үзлэгт зориулан 11,936.0 мянган төгрөг;
- Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс резидентийн сургалтын төлбөрт 182.4 мянган төгрөг;
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас “Настны цогц эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний удирдамж хэрэгжүүлэх төслийн хүрээнд 25,642.4 мянган төгрөг;
- Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4 төслийн хүрээнд 384.0 мянган төгрөг;
- Эрүүл мэндийн яамнаас геронтологи, гериаторын чиглэлээр эмнэл зүйн стандарт, заавар боловсруулах үйл ажиллагааны санхүүжилтэд 10,361.0 мянган төгрөг тус тус төвлөрсөн байна.

Дээрх санхүүжилтийг Сангийн сайдын 73 тоот тушаалаар төрийн сангийн журмын дагуу төсвийн зарцуулах эрх авч, эмнэлгийн захирлын баталсан төсөв, удирдамжийн дагуу зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 18 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 23 эрсдэл тодорхойлж нийт 23 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 106,299.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 12,602.2 мянган төгрөгийн зөрчлийг залруулж, 4,245.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн 2 акт тогтоож, 20,297.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 69,154.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 12,602.2 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан. Үүнд:

- Газар эзэмших эрх биет бус хөрөнгөд 326.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан;
- Нэмэлт төсвийн санхүүжилтийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнг 11,552.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланг цэвэр дүнгээр тайлагнаагүй, төвлөрүүлэх шилжүүлэг 723.5 мянган төгрөгийг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнд оруулан тайлагнасан;

Аудитаар залруулагдаагүй нийт 93,697.1 мянган төгрөгийн 11 зөрчлийн 2 зөрчилд 4,245.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3 зөрчилд 20,297.4 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж байна. Үүнд:

1. Засгийн газрын тогтоолоор баталсан үндсэн цалингийн хэмжээг зөрүүтэй тогтоосноос 6 ажилтанд 1,914.8 мянган төгрөгийг илүү олгосон нь Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын 7 дугаар хавсралтаар батлагдсан Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээг баримтлаагүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Цалингийн урьдчилгаанд 3 ажилтанд 2,330.2 мянган төгрөг олгосныг буцаан суутган авахгүйгээр цалингийн зардалд бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4-т “үнэн зөв байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох
3. Улирлын үр дүнгийн урамшууллаас гадна тайлант оны 12 сард бүх ажилтанд үндсэн цалингийн 60 хүртэлх хувиар нийт 15,209.8 мянган төгрөгийн урамшууллыг хавтгайруулан олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалттай нийцэхгүй байна.
4. Ээлжийн амралтын тооцоог давтан шалгахад 28 ажилтанд 4,685.4 мянган төгрөг илүү, 2 ажилтанд 402.2 мянган төгрөг дутуу, ажлаас халагдсан 7 ажилтны амралтын тооцооны олговрыг олгоогүй зэрэг зөрчлүүд нь “үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 15-д “Ажилтан ажлаас халагдах үед ажил олгогч нь түүнтэй ээлжийн амралтын тооцоог заавал хийнэ” тус тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ээлжийн амралтын олговор тооцох журам”-ын 7-д “Тухайн ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тодорхойлохдоо өмнөх ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тооцоход оруулсан

хугацааны дундаж цалин хөлсийг давхардуулан оруулж тооцохгүй” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

5. Тус байгууллагын эзэмшлийн гадаад талбайг төлбөртэй зогсоолоор ашиглаж, хураасан төлбөрийн орлогыг бүртгэлд тусгахгүйгээр эмнэлгийн барилгын гадна пассатны болон цахилгаан, дулааны урсгал засварт зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.11-д “Газар, байгалийн баялгийн нөөцийг хуульд заасан хэлбэрээр эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдон бий болох орлого нь төсвийн орлого байна”, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн 2011 оны 7/66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах журам”-ын 5.1.2-т заасан Хэрэгжүүлэгч байгууллага нь зогсоолын үйлчилгээнээс орох орлогын 60 хувийг Авто замын санд төвлөрүүлэх” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитаар илэрсэн 69,154.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус байгууллагын худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх, үндсэн хөрөнгийн бүртгэлийг стандартын дагуу бүртгэлд тусгасан эсэх асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэв.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Геронтологийн үндэсний төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 138 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 80 хувьтай байна. Аудитын түүвэр тооллогоор зөрчлүүд илэрсэн нь үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг чанартай, үнэн зөв хийх тухай зөвлөмжийн биелэлтийг хангалтгүй байна гэж үзсэн.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Геронтологийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 93,697.1 мянган төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 18,193.9 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр байгаа тул хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Геронтологийн үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв бэлтгэсэн эсэхийг шалгахад дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Үр дүнгийн урамшуулалд 34,149.8 мянган төгрөгийг гарт олгосон боловч төсвийн гүйцэтгэлийн тайланд 41,418.9 мянган төгрөгөөр тайлагнаж 7,269.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Хоол унааны олговорт 44,186.0 мянган төгрөг олгосон байхад төсвийн гүйцэтгэлийн тайланд 60,060.0 мянган төгрөгөөр тайлагнаж 15,874.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн;
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг ангилахдаа гүйцэтгэлээр бус батлагдсан төлөвлөгөөний дүнг тайлагнаж огт зөрүүгүй байдлаар буруу тайлагнасан;
- Гэрэл, цахилгааны зардлын ангиллаас 110.2 мянган төгрөгийн ярианы төлбөрийг зарцуулж бүртгэсэн;
- Тайлант оны 12 дугаар сард өмнөх саруудын тогтмол дүнгээс их буюу 1,432.6 мянган төгрөгийн дулааны төлбөрийг УБДС ТӨХК-д шилжүүлж, оны эцэст 582.0 мянган төгрөгийн илүү төлөлттэй гарсныг авлагаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй;
- Нэмэлт төсвийн санхүүжилтийн дансны 31,684.0 мянган төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардлын ангиллаас 25,864.7 мянган төгрөгийн цалин хөлс олгосон;
- Үр дүнгийн урамшуулалд 42,874.2 мянган төгрөг тооцож олгосныг Санхүүгийн үр дүнгийн тайлангийн урамшуулал хэсэгт тусгаагүй, унаа хоолны хөнгөлөлт, нэмэгдэл цалингийн зардлын ангилалд тайлагнагдсан зардлууд нь төсвийн гүйцэтгэлийн тайлантай уялдаагүй буруу бэлтгэгдэн гарсан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.2 төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд

захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” 22 дугаар зүйлийн 22.5-д “Төсвийн ангиллын зүйлд санаатайгаар буруу мэдээлэл оруулж төсвийн орлого, зарлагын хэмжээг өөрчлөхийг хориглоно” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн төлөвлөгөөг үндэслэлгүй боловсруулсан байх, гүйцэтгэлийг буруу тайлагнасан байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөх, төсвийн зарлагын ангиллыг зөрүүгүйгээр зарцуулах, төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлд дэлгэрэнгүй тайлбар өгсөн болно.

3.2 Цалин хөлстэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Цалин хөлсний тооцооллыг буруу хийснээс дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Ур чадварын нэмэгдлийг сар тутам олгохгүйгээр 4 дүгээр сард 1, 2, 3 сарын буюу нийт 3 сарын, 6 дугаар сард 5 болон 6 сарын нийт 2 сарын, 11 дүгээр сард 10 болон 11 дүгээр сарын нийт 2 сарын ур чадварын нэмэгдлийг бөөнд нь олгосон;
- Захирлын тушаалд заасан хувь хэмжээгээр ур чадварын нэмэгдлийг олгосон эсэхийг тулган шалгахад нийт 8 ажилтанд 638.1 мянган төгрөгийг илүү, 8 ажилтанд 547.2 мянган төгрөгийн дутуу олгосон;
- Хавсран ажилласны нэмэгдлийг тушаалын дагуу тооцож олгоогүйгээс 4 ажилтанд 245.5 мянган төгрөгийг илүү, 3 ажилтанд 195.0 мянган төгрөгийг дутуу олгосон.
- Аудитаар 4 сарын цагийн бүртгэлийг түүвэрлэн тулган шалгалт хийхэд 5 ажилтны цагийн бүртгэлийг зөрүүтэй бодсон, цагийн бүртгэлд ажилтны нэрийг буруу оруулсан байна.
- Тайлант онд 2 ажилтанд 3 сарын, 1 ажилтанд 2 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нийт 3 ажилтанд 7,796.9 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон байна.

Эдгээр нь төсвийг хэмнэлттэй, үр ашигтайгаар зарцуулах зарчим, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4-т “үнэн зөв байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Цалин хөлсний нэмэгдлийг буруу тооцоож олгосон байх, цагийн бүртгэлийг үнэн зөв хөтлөөгүй байх, цалинг тооцоолохдоо цагийн бүртгэлээс зөрүүгүй бодож олгосон байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 382 тоот тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын дагуу ур чадварын нэмэгдлийг сар тутам олгох, шалгуур үзүүлэлтийг оновчтой болгох, ур чадвар, үр дүн, хавсран ажилласны нэмэгдлийг олгохдоо тооцооллын алдаа гаргахгүй байх, төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлд дэлгэрэнгүй тайлбар өгсөн болно.

3.3 Дүрмийн сантай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Тус байгууллагын санхүүгийн тайланд засгийн газрын оруулсан капитал 478,903.3 мянган төгрөг байхад улсын бүртгэлийн гэрчилгээнд 42,730.0 мянган төгрөгөөр тусгагдаж 436,173.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.

Засгийн газрын оруулсан капиталын дүн санхүүгийн байдлын тайланд 72,629.7 мянган төгрөг байхад улсын бүртгэлийн гэрчилгээнд 70,863.5 төгрөгөөр тусгагдаж 1,766.2 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

Энэ нь Хууль зүйн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалын хавсралт “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2-т “Хуулийн этгээдийн дараах мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд өөрөөр заагаагүй бол ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ: 8.2.3-д хувь нийлүүлсэн хөрөнгө” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланд тусгагдсан дүрмийн сангийн хэмжээ нь улсын бүртгэлийн гэрчилгээтэй ;

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Дүрмийн сангийн өөрчлөлтийг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгах;

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2018 оны дахин үнэлгээгээр дүрмийн санд өөрчлөлт орсныг бүртгүүлж амжаагүй байсан.

3.4 Татварын тайлангийн талаар:

3.4.1 Илрүүлэлт:

Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татварын тайланд тайлагнагдах 27,997.4 мянган төгрөгийн ажлын хөлсийг Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан орлогын албан татварын тайлангийн төрөлд тайлагнаж 321.9 мянган төгрөгийн ХХОАТ-ыг хувь хүнээс илүү суутган авч, татварын ногдол үүсгэсэн.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Татварын тооцооллыг буруу хийсэн байх;

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Гэрээт ажилтанд ажлын хөлс олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татварын тооцооллыг хуулийн дагуу тооцох, татварын тайланд

тусгахдаа Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татварын тайланд тусгах;

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

ХХОАТ-ыг суутгахад нийгмийн даатгалын шимтгэл хасаагүй дүнгээс суутгасан байна.

3.5 Бараа материалын бүртгэлийн талаар:

3.5.1 Илрүүлэлт:

Бараа материалын түүвэр тооллогод 53 нэр төрлийн 53,088.1 мянган төгрөгийн бараа материалыг хамруулахад дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- 27 төрлийн 20,674.8 мянган төгрөгийн хангамжийн материалыг ашиглалтад тавьж олгосон боловч данснаас хасаагүй;
- 2018 онд Оношлуур худалдан авах гэрээ байгуулж 10,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч оношлуурыг хадгалах лаборатори байхгүй, эрдэм шинжилгээний судалгаа хариуцсан мэргэжилтэн байхгүй шалтгаанаар одоог хүртэл бараа материалыг хүлээн аваагүй байгаа;
- Нийт 5 төрлийн 3,208.9 мянган төгрөгийн ном, сэтгүүл, гарын авлага, 5,181.7 мянган төгрөгийн ажлын хувцас, хулдаас зэрэг бараа материалуудыг зарцуулсан боловч бараа материалын данснаас хасаагүй;
- Бараа материалын нэршлийг ойлгомжгүй бүртгэсэн, эмх цэгц хангалтгүй, тооллогыг үр дүнгүй хийсэн.

Эдгээр зөрчлүүд нь 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1.аж ахуйн бүх ажил, гүйлгээ” тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Бараа материалыг холбогдох стандарт, дүрэм, журмын дагуу бүртгэхгүй байх;

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Бараа материалын тооллогыг үр дүнтэй зохион байгуулах, ашиглалтад тавьж олгосон бараа материалыг данснаас хасах, 10,000.0 мянган төгрөгийн оношлуурыг шаардлагатай гэж үзвэл хүлээн авах, бараа материалыг хүлээн аваагүй тохиолдолд авлагын данс руу залруулга хийх;

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлд дэлгэрэнгүй тайлбар өгсөн болно.

3.6 Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар:

3.6.1 Илрүүлэлт:

Анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн 80 нэр төрлийн 81,600.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй үйл ажиллагаанд ашиглаж байна. Энэ нь УСНББОУС-17-68-д "Хөрөнгийн бодит үнэ цэнэ дансны үнээсээ хэтэрсэн байсан ч гэсэн үлдэх өртөг нь дансны үнээс хэтрээгүй байх хүртэл элэгдлийг хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглахаар тооцсон хугацааны туршид системтэйгээр хуваарилна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.6.2 Эрсдэл:

Үндсэн хөрөнгийг холбогдох стандарт, дүрэм, журмын дагуу бүртгэхгүй байх;

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн ашиглалтад байгаа хөрөнгийг өртөг нөхөх хүсэлт гарган дансны үнийг нэмэгдүүлэх, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө стандартад заасны дагуу ашиглалтын хугацаа үлдэгдэл өртгийг тайлант хугацаа бүрийн эцэст хяналт хийж ашиглалтын хугацааг бодитой тогтоох;

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Элэгдлээрээ өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг хийгээгүй байгаа 2020 оны эхний улиралд багтаж ажлыг зохион байгуулж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1. Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	123,150,260.79	105,479,931.70
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	500,000.00	1,800.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	500,000.00	00.00
31110	Төгрөг	500,000.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	1,800.00
3121	Төгрөг	00.00	1,800.00
31213	Арилжааны банк дахь харилцах	00.00	1,800.00
33	АВЛАГА	22,392,605.10	00.00
335	Бусад авлага	22,392,605.10	00.00
3351	Байгууллагаас авах авлага	22,392,605.10	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	100,257,655.69	105,478,131.70
351	Түүхий эд материал	14,168,218.49	18,804,017.50
35110	Тусгай зориулалттай материал	80,000.00	80,000.00
35130	Эм боох материал	14,088,218.49	18,724,017.50
35300	Бэлэн бүтээгдэхүүн	8,315,120.00	7,895,280.00
354	Хангамжийн материал	77,774,317.20	78,778,834.20
35410	Бичиг хэргийн материал	1,902,840.00	1,091,579.00
35420	Аж ахуйн материал	638,801.00	1,222,319.00
35430	Сэлбэг хэрэгсэл	92,050.00	298,950.00
35440	Түлш, шатах тослох материал	688,277.40	670,142.40
35470	Бусад хангамжийн материал	74,452,348.80	75,495,843.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	401,714,329.38	362,998,562.73
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00.00	00.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	401,714,329.38	362,671,884.51
392	Биет хөрөнгө	342,912,249.38	304,196,482.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	125,920,677.50	125,920,677.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-20,610,810.00	-36,044,163.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	94,536,549.00	75,946,549.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-42,894,313.57	-34,719,715.49
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	351,403,769.05	366,332,169.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	-176,304,282.00	-219,877,220.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,111,970.00	43,436,470.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,753,880.60	-18,441,213.83
39217	Ном	1,502,570.00	1,642,930.00
393	Биет бус хөрөнгө	58,802,080.00	58,475,401.78
39301	Програм хангамж	1,470,000.00	1,470,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,470,000.00	-1,470,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	58,802,080.00	58,802,080.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	524,864,590.17	468,478,494.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	524,864,590.17	468,478,494.43
51	Засгийн газрын хувь оролцоо	524,864,590.17	468,151,816.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	478,903,308.00	478,903,308.00
51101	Өмч: - төрийн	478,903,308.00	478,903,308.00
512	Хуримтлагдсан үр дүн	-83,537,021.50	-140,249,795.46
51210	Өмнөх үеийн үр дүн	-83,537,021.50	-83,537,021.50
